МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН
ТУШААЛ

2015 оны 07 сарын 10 өдөр Дугаар 204 Улаанбаатар хот

Тээврийн хэрэгслийн техникийн хяналт,
авто үйлчилгээ, бүртгэлийн үйл ажиллагааг
боловсронгуй болгох дунд хугацааны
хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Тээврийн хэрэгслийн техникийн хяналт, авто үйлчилгээ, бүртгэлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох дунд хугацааны хөтөлбөр /2015-2020/-ийг 1 дүгээр хавсралтаар, хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар ханган ажиллахыг Авто замын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Доржханд/-т, хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсөвт тусгах, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг татан оролцуулах, хандивлагч орон, олон улсын банк, санхүүгийн байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Стратегийн бодлого, төлөвлөлт, хамтын ажиллагааны газар /С.Адъяасүрэн/, "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ-ын захирал /Н.Пунцаг/ нарт тус тус үүрэг болгосугай.

3. Хөтөлбөрийн хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлагнаж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Т.Зулзүсэм/-т үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Ж.Бат-эрдэнэ/-д даалгасугай.

САЙД Н.ТӨМӨРХҮҮ

Зам, тээврийн сайдын 2015 оны 07 дугаар
сарын 10-ны 204 тоот тушаалын
1 дугаар хавсралт

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН ХЯНАЛТ, АВТО ҮЙЛЧИЛГЭЭ, БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ БОЛОВСРОНГҮЙ БОЛГОХ ДУНД ХУГАЦААНЫ ХӨТӨЛБӨР

Нэг. Үндэслэл шаардлага

1.1. Нийтлэг үндэслэл

Өсөн нэмэгдэж буй нийгмийн эрэлт хэрэгцээг хангах, түүхий эд болон бүтээгдэхүүнийг зах зээлд хүргэх, үйлдвэрлэл, худалдааны эргэлтийг нэмэгдүүлэхэд авто тээврийн салбар чухал үүрэгтэй.

Улс орны эдийн засаг, нийгмийн хөгжилтэй уялдан тээврийн хэрэгслийн тоо сүүлийн жилүүдэд хурдацтай өсөж байгаа нь тээврийн салбарын төдийгүй бусад салбарын бүтээгдэхүүн үйлчилгээг нэмэгдүүлж байгаа сайн талтай боловч түүний ашиглалтын улмаас хүний эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлж буй сөрөг нөлөөлөл буурахгүй байгаа нь энэхүү хөтөлбөрийг боловсруулах үндэслэл болж байна.

Тээврийн эрэлт хэрэгцээг хангахад бүтээмж өндөртэй, зардал багатай, аюулгүй, шуурхай тээвэрлэлтийн үйлчилгээ шаардлагатай бөгөөд тухайн үйлчилгээг үзүүлэхийн тулд тээврийн хэрэгслийн ашиглалт болон түүнд тавих хяналтыг сайжруулах, хүн ам, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад төрийн зохицуулалт зайлшгүй шаардлагатай.

Замын хөдөлгөөний аюулгүй байдлын үзүүлэлтийн түвшингээр дэлхийд тэргүүлэгч орнуудын туршлагаас харахад тээврийн хэрэгслийн ашиглалтын улмаас үүсэх сөрөг нөлөөллийг бууруулах үр дүнтэй арга хэмжээний нэг нь олон улс, бүс нутаг, үндэсний хэмжээнд алсын хараатай зорилт бүхий стратеги, үйл ажиллагааны хөтөлбөр, төсөл боловсруулан, төрийн бодлого болгон хэрэгжүүлсэн явдал байна.

1.2. Хөтөлбөр боловсруулах эрх зүйн үндэслэл

Энэхүү хөтөлбөрийг боловсруулах эрх зүйн үндэслэл дараах шаардлагаас үндэслэн гарч байна:

1.1.1. Засгийн газрын 2012 оны 146 дугаар тогтоолоор батлагдсан “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах үндэсний стратеги”-д авто тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний мэдээллийн санг бий болгох замаар “Үйлчилгээ-Оношилгоо-Хяналтын” нэгдсэн системийг бүрдүүлэх замаар зам, тээврийн ослыг бууруулах;

1.1.2. Монгол Улсын Засгийн Газрын 2012-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт “авто тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтыг боловсронгуй болгож, орчин үеийн мэдээллийн технологийн ололтыг нэвтрүүлэн авто тээврийн хөдөлгөөнийг улсын хэмжээнд хянах төв байгуулах”.

1.2. Хөтөлбөр боловсруулах практик үндэслэл

Тээврийн хэрэгслийн техникийн хяналт, авто үйлчилгээ, бүртгэлийн үйл ажиллагааг боловсронгуй болгох практик үндэслэл дараах шаардлагаас үндэслэн гарч байна:

1.2.1. 2001-2004 онд хэрэгжүүлсэн "Тээвэр хөгжүүлэх" төслийн хүрээнд тээврийн хэрэгсэлд техникийн хяналтын үзлэг хийх төвүүдийг байгуулах үед улсын хэмжээнд 131 144, нийслэлийн хэмжээнд 48 178 тээврийн хэрэгсэлтэй, жилийн дундаж өсөлт 13 орчим хувь байсан бол 2014 оны эцсийн байдлаар улсын хэмжээнд 739 589, нийслэлд 410 516 тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгаа нь төсөл хэрэгжих үеэс өнөөдрийг хүртэл нийт тээврийн хэрэгслийн тоо 4 дахин нэмэгдсэн, үүний 35-40 хувь нь техникийн хяналтын үзлэгт хамрагдахгүй байна.

1.2.2. Техникийн хяналтын үзлэгийн төвд ашиглагдаж буй үндсэн тоног төхөөрөмжүүд 10 гаруй жил ашиглагдаж техникийн эвдрэл, гэмтэл ихээр гарч ашиглалтын зардал нэмэгдэхийн зэрэгцээ сүүлийн үеийн авто машины хийцийн онцлог, технологийн өөрчлөлтөд нийцэхгүй болсон.

1.2.3. Тээврийн хэрэгслийн улсын дугаар давхардах, үйлдвэрлэгчийн зөвшөөрөлгүй марк, зориулалтыг өөрчлөх, ашиглагдахаа больсон тээврийн хэрэгслийг бүртгэлээс хасуулахгүй байх зэрэг зөрчил илрэхийн зэрэгцээ Монгол Улсад үйлдвэрлэсэн, угсарсан тээврийн хэрэгслийг улсын бүртгэлд бүртгэх эрх зүйн зохицуулалт бүрдээгүй байна.

1.2.4. Техник, технологийн хөгжлийн дагуу тээврийн хэрэгслийн хийц, технологи асар хурдацтай өөрчлөгдөж, үүнийг дагаад тээврийн хэрэгслийн үнэ ч нэмэгдэж байна. Гэтэл манай улсад тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний чанар, аюулгүй байдалд тавигдах шаардлага, хяналт, зохицуулалт, хариуцлагын тогтолцоо хангалттай бүрдэж чадаагүй байна.

Хоёр. Эрхэм зорилго

Эрэлтэд нийцсэн, техник, технологийн дэвшилд суурилсан тээврийн хэрэгслийн техникийн хяналт, авто үйлчилгээ, бүртгэлийн цогц үйлчилгээг нэвтрүүлэх.

Гурав. Хөтөлбөрийн гол зорилт

Хөтөлбөрийн эрхэм зорилгын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны гол зорилтуудыг хэрэгжүүлнэ:

3.1. Тээврийн хэрэгслийн техникийн хяналт, авто үйлчилгээ, бүртгэлийн тогтолцоог шинэчлэх "Эрэлтэд нийцсэн эрх зүйн" орчинг бүрдүүлнэ;

3.2. Нийгмийн эрэлт хэрэгцээ, техник технологийн дэвшилд суурилсан үйлчилгээг нэвтрүүлэх;

3.3. Хүний нөөцийг чадавхжуулах "чадамжид суурилсан тогтолцоо"-г бүрдүүлнэ;

3.4. Техникийн хяналтын үзлэг, авто үйлчилгээ, бүртгэлийн үйл ажиллагааны техник, тоног төхөөрөмж, програм хангамжийг шинэчлэн сайжруулах "Технологийн шинэчлэл" хийх замаар олон улсын жишигт нийцүүлнэ;

3.5. Техникийн хяналтын үзлэг, авто үйлчилгээ, бүртгэл, гааль, татвар, даатгалын "Нэг систем, нэг цонх" нэгдсэн системийг бүрдүүлнэ.

Дөрөв. Баримтлах зарчим, хамрах хүрээ

4.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмуудыг баримтална:

4.1.1. үндэсний болон салбарын стратеги, бодлого, хөтөлбөртэй нягт уялдуулах;

4.1.2. нийгмийн болон хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн үйлчилгээг нэвтрүүлэх, үр өгөөжийг нэмэгдүүлэх;

4.1.3. тээврийн хэрэгслийн техникийн бүрэн бус байдлаас шалтгаалан гарч буй зам тээврийн осол болон тээврийн хэрэгслийн ашиглалтын улмаас хүн ам, хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах;

4.1.4. техник, технологийн дэвшил, инженер техникийн ажилчдын чадамжид суурилах, олон улсын хэмжээнд баримталж буй бодлого чиглэлтэй нийцсэн байх;

4.1.5. салбар хоорондын ажлын болон мэдээллийн уялдаа холбоог сайжруулах, төр-хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан идэвхтэй оролцоог хангах.

4.2. Энэхүү хөтөлбөрийн хамрах хүрээ нь:

4.2.1. тээврийн хэрэгслийн техникийн хяналт, авто үйлчилгээ, бүртгэлийн үйл ажиллагааг бодлогын удирдамжаар хангах, хэрэгжилтийг зохион байгуулах төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагууд;
4.2.2. тээврийн хэрэгслийн техникийн хяналт, бүртгэл, авто үйлчилгээтэй нэгдмэл үйл ажиллагаатай гааль, татвар, даатгал, хяналт, стандартчилал, тохирлын үнэлгээний байгууллагууд.
4.2.3. энэ чиглэлийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх бусад байгууллагууд;

Тав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх үйл ажиллагаа

5.1. Тээврийн хэрэгслийн техникийн хяналт, авто үйлчилгээ, бүртгэлийн тогтолцоог шинэчлэх "Эрэлтэд нийцсэн эрх зүйн" орчинг бүрдүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

5.1.1. үйлчилгээний чанар, хамрах хүрээг нэмэгдүүлэх, үйлчлүүлэгчийн сэтгэл ханамж, эрэлтэд нийцсэн зохицуулалтыг бий болгоно;

5.1.2. тээврийн хэрэгслийн гаалийн бүрдүүлэлт, татвар, даатгал, бүртгэл, техникийн хяналт, авто үйлчилгээний мэдээллийн нэгдсэн сан байгуулах, ашиглах, мэдээлэл солилцох, мэдээллийг хадгалах, мэдээллийн сангийн аюулгүй байдлыг хангах зохицуулалтыг бүрдүүлнэ;

5.1.3. техникийн хяналтын үзлэгийн төвүүдийн техник, тоног төхөөрөмж, стандарт, нормыг шинэчлэх сан байгуулах, ашиглах эрх зүйн орчинг бүрдүүлнэ;

5.1.4. инженер, техникийн ажилтнуудыг сургах, мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлнэ;

5.1.5. авто үйлчилгээ, тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөлтийн үйл ажиллагааны хариуцлагын тогтолцоог сайжруулах зохицуулалтыг бүрдүүлнэ;

5.1.6. ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгслийг устгах, дахин боловсруулах үйлдвэрлэлийн эрх зүйн зохицуулалтыг бий болгоно;

5.1.7. Монгол Улсад үйлдвэрлэсэн, угсарсан тээврийн хэрэгсэлд үйлдвэрлэгчийн таних тэмдэг олгох, аюулгүй байдлыг шалгах зохицуулалтыг бий болгоно.

5.2. Нийгмийн эрэлт хэрэгцээ, техник технологийн дэвшилд суурилсан үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ;

5.2.1. тээврийн хэрэгслийн техникийн хяналт, авто үйлчилгээ, бүртгэлийн үйл ажиллагаа үйлчилгээний менежментийг сайжруулах ажлыг зохион байгуулна.

5.2.2. тээврийн хэрэгслийн хийц, технологийн онцлогт тохируулан техникийн хяналтын үзлэг, засвар үйлчилгээний төрлийг нэмэгдүүлнэ;

5.2.3. тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, дугаар олгох үйлчилгээнд цахим үйлчилгээний системийг нэвтрүүлнэ;

5.2.4. техникийн хяналтын үзлэгийн төвийг түшиглэн сургалт, дадлагын төв байгуулна;

5.2.5. тоног төхөөрөмжийн хүчин чадал, инженер, техникийн ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг харгалзан үйл ажиллагааны зэрэглэл тогтооно;

5.2.6. техникийн хяналт, бүртгэл, авто үйлчилгээний байгууллагуудын дотоодын хяналтыг хөгжүүлэх замаар хариуцлагын механизмыг хөгжүүлнэ;

5.2.7. техникийн хяналтын үзлэгийн дүгнэлтэд үндэслэн хөдөлгөөний аюулгүй байдлын болон техникийн аюулгүй ажиллагааг хангах талаар хэрэглэгчдэд зөвлөмж өгөх "зөвлөн туслах" үйлчилгээг нэвтрүүлэн хөгжүүлнэ;

5.2.8. ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгслийг устгах, дахин боловсруулах үйлдвэрлэлийг хөгжүүлнэ;

5.2.9. техникийн хяналтын үзлэгийн дүнд суурилсан судалгаа, шинжилгээ хийх, санал, зөвлөмж, дүгнэлт боловсруулан холбогдох байгууллагыг мэдээллээр хангана;

5.2.10. тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэлийн хүрээнд татварын байгууллагатай хамтран "татварын өршөөлийн хууль" гарган хэрэгжүүлнэ.

5.2.11. Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг, бүртгэлийн үйл ажиллагаа, авто үйлчилгээний чиглэлээр Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах;

5.3. Хүний нөөцийг чадавхжуулах "чадамжид суурилсан тогтолцоо"-г бүрдүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.3.1. инженер, техникийн болон мэргэжилтэй ажилтны мэргэжил, ур чадварыг стандартчилан, мэргэжлийн зэрэг олгох тогтолцоог шинэчлэнэ;

5.3.2. тээврийн хэрэгслийн бүртгэлийн чиглэлээр мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг боловсруулан мөрдүүлнэ;

5.3.3. инженер, техникийн болон мэргэжилтэй ажилтныг бусад оронд сургах, дадлагажуулах, мэргэжилтэн солилцох хөтөлбөрт хамруулах зэргээр өрсөлдөх чадвар бүхий мэргэжлийн ажилтан бэлтгэнэ;

5.3.4. инженер техникийн болон мэргэжилтэй ажилтны ажиллах нөхцөл, эрүүл ахуй, аюулгүй ажиллагааг хангасан орчин нөхцлийг бүрдүүлнэ.

5.4. Техникийн хяналтын үзлэг, авто үйлчилгээ, бүртгэлийн техник, тоног төхөөрөмж, програм хангамжийг шинэчлэн сайжруулах "Технологийн шинэчлэл" хийж олон улсын жишигт нийцүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.4.1. техникийн хяналтын үзлэгийн төвийн тоног төхөөрөмжийг тээврийн хэрэгслийн хийцийн онцлогт нийцүүлэн олон улсын дэвшилтэд техник тоног төхөөрөмжөөр үе шаттайгаар шинэчлэнэ;

5.4.2. техникийн хяналтын үзлэгийн тоног төхөөрөмжийн ажиллагаа, хэмжлийн нэгдмэл байдлыг хангах зорилго бүхий засвар, үйлчилгээ, баталгаажуулалт хийх лаборатори байгуулна;

5.4.3. мотоциклд техникийн хяналтын үзлэг хийх тоног төхөөрөмжийг нэмэгдүүлнэ;

5.4.4. стандартын шаардлага хангасан өөрийн эзэмшлийн барилга, байгууламжтай болохыг бодлогоор дэмжинэ;

5.4.5. техникийн хяналтын үзлэгийн төвийн барилгын стандартын шаардлага хангасан нэг маягийн зураг төслийг гаргаж хэрэгжүүлнэ;

5.4.6. техникийн хяналтын үзлэгийн төвийн байр нь ажилчдын ажиллах нөхцөлийг бүрэн хангасан, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан байна.

5.5. Техникийн хяналтын үзлэг, авто үйлчилгээ, бүртгэл, гааль, татвар, даатгалын "Нэг систем, нэг цонх" нэгдсэн системийг бүрдүүлэх зорилтын хүрээнд дараах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

5.5.1. хэрэглэгчдэд шуурхай үйлчилгээ үзүүлэх, хамрагдах хүрээг нэмэгдүүлэх "цахим үйлчилгээ" системийг нэвтрүүлнэ;

5.5.2. тээврийн хэрэгслийн татвар, даатгал, хяналт, бүртгэлийн нэг цонхны үйлчилгээг бий болгох;

5.5.3. нэг систем, нэг цонх үйлчилгээний стандарт тогтоон мөрдүүлэх;

Зургаа. Хэрэгжүүлэх үе шат

6.1. Хөтөлбөрийг 2015-2020 онд хэрэгжүүлнэ.

6.2. Хөтөлбөрийг урт, дунд хугацааны стратегийн хөтөлбөр, жил бүрийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулан хэрэгжүүлнэ.

Долоо. Хөтөлбөрийн үр дүн

7.1. хөтөлбөр хэрэгжсэнээр дараах үр дүн гарна:

7.1.1. техникийн хяналтын үзлэг, авто үйлчилгээ, бүртгэлийн үйл ажиллагаа, үйлчилгээний хариуцлагын тогтолцоо шинэчлэгдэж эрэлтэд нийцсэн үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчин бүрдэнэ.

7.1.2. үйлчилгээний чанар, үр дүн дээшилж, тээврийн хэрэгслийн бүрэн бус байдлаас шалтгаалсан ослын тоо, тээврийн хэрэгслийн ашиглалтын улмаас үүсч буй агаарын бохирдлын хэмжээг бууруулна.

7.1.3. техникийн хяналтын үзлэг, тээврийн хэрэгслийн бүртгэл, авто үйлчилгээний нэгдсэн тогтолцоо бүрэлдэн, мэдээлэл шуурхай солилцох боломж бүрдэж төрийн үйлчилгээний шат дамжлага багасна.

7.1.4. техникийн хяналтын үзлэгийн барилга байгууламж, ажилчдын ажиллах нөхцөл сайжирч, дэвшилтэд шинэ техник технологи, тоног төхөөрөмжийг нэвтрүүлнэ.

Найм. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах

8.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг салбарын урт, дунд хугацааны бодлогын баримт бичиг, төлөвлөгөөтэй уялдуулан зохион байгуулна.

8.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах, байгууллага хоорондын хамтын ажиллагааг уялдуулан зохицуулах ажлыг авто тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хариуцна.

8.3. Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг зохион байгуулах байгууллага, аж ахуйн нэгж нь энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахтай холбогдуулан төсөл, төлөвлөгөө боловсруулан ажиллана.

8.4. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангах, үйл ажиллагааны хэрэгжилтийн явцыг тайлагнахыг холбогдох төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагууд хариуцан ажиллана.

Ес. Санхүүжилт

9.1. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

9.1.1. Улсын төсөв;

9.1.2. аж ахуйн нэгж, байгууллага өөрийн орлого;

9.1.3. зээл, тусламж, төсөл;

9.1.4. концесс.

Арав. Хөтөлбөрийн үнэлгээ, хяналт шинжилгээ, шалгуур үзүүлэлт,

10.1. Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж жил бүр зам, тээврийн сайдын зөвлөлд танилцуулна.

10.2. Холбогдох төрийн болон төрийн бус, хувийн хэвшлийн байгууллагууд нь хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хагас, бүтэн жилээр хийж Автотээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тайлагнана.

10.3. Хөтөлбөрийн хэрэгжилтийг үнэлэхдээ дараах шалгуур үзүүлэлтийг удирдлага болгоно.

	Шалгуур үзүүлэлт	2015 оны суурь түвшин	2018 онд хүрэх түвшин	2020 онд хүрэх түвшин
Нэг. Техникийн хяналтын үзлэг				
1.1.	Техникийн бүрэн бус байдлаас болж гарч буй зам тээврийн ослын эзлэх хувь	1,9%	1%	0.5%
1.2	Тээврийн хэрэгслийн ашиглалтаас үүдэлтэй агаарын бохирдлын хэмжээ	10%	5%	1%
1.3	Стандартын шаардлага хангасан барилга, байгууламжийн эзлэх хувь	54%	75%	100%
1.4	Техникийн хяналтын үзлэгийн төвийн тоо	23	28	35
1.5	Техникийн хяналтын үзлэгийн нэг сувагт ногдох тээврийн хэрэгслийн тоо	28 582	23 000	20 000
1.6	Нийт тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгт хамрагдах хувь	63.5%	85%	100%
1.7	Шинээр нэвтрүүлсэн техник, тоног төхөөрөмжийн эзлэх хувь	5%	30%	50%
1.8	Тоног төхөөрөмжийн эдэлгээний дундаж хугацаа /жилээр/	20	10	5
1.9	Инженер, техникийн ажилтнуудын мэргэшсэн байдал	30%	100%	100%
1.10	Иргэд, байгууллагын сэтгэл ханамжийн хувь	20%	70%	100%

	/судалгаагаар/			
Хоёр. Тээврийн хэрэгслийн бүртгэл				
2.1.	Бүртгэлийн үйлчилгээний цэгийн тоо	26	35	45
2.2.	Нэг тээврийн хэрэгсэл бүртгэх дундаж хугацаа	50 мин	30 мин	20 мин
2.3.	Тээврийн хэрэгслийн бүртгэлээр мэргэшсэн ажилтны тоо	0%	40%	100%
2.4.	Мэдээллийн сангийн мэдээллийн зөрүү	30%	0	0
2.5.	Бүртгэлийн үйл ажиллагаа цахим хэлбэрт шилжсэн байдал	0%	50%	100%
2.6.	Иргэд, байгууллагын сэтгэл ханамжийн хувь /судалгаагаар/	15%	50%	100%
Гурав. Авто үйлчилгээ				
3.1.	Инженер, техникийн ажилтнуудын мэргэшсэн ба	10%	60%	100%

Зам, тээврийн сайдын 2015 оны 07 дугаар
сарын 10 -ны 204 тоот тушаалын
2 дугаар хавсралт

ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ТЕХНИКИЙН ХЯНАЛТ, АВТО ҮЙЛЧИЛГЭЭ, БҮРТГЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ДУНД ХУГАЦААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үйл ажиллагаа	Санхүүжилт /сая.төг/	Хариуцах байгууллага	Хамтран хэрэгжүүлэх байгууллага	Хэрэгжүүлэх хугацаа
Нэг. Тээврийн хэрэгслийн техникийн хяналт, авто үйлчилгээ, бүртгэлийн тогтолцоог шинэчлэх "Эрэлтэд нийцсэн эрх зүй" орчинг бүрдүүлнэ					
1.1.	Техникийн хяналтын үзлэг, авто үйлчилгээ, бүртгэлийн тогтолцоо, хяналт хариуцлагыг сайжруулах чиглэлээр зохих хуульд нэмэлт өөрчлөлт оруулах	20.0	ЗТЯ	АТҮТ	2015-2016 он
1.2.	Техникийн хяналтын үзлэгт зөвлөмжийн үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр нийтээр дагаж мөрдөх дүрэм, журам, стандартад өөрчлөлт оруулах.	5.0	ЗТЯ	АТҮТ	2015-2016 он
1.3.	Тээврийн хэрэгслийн гаалийн бүрдүүлэлт, татвар, даатгал, техникийн хяналт, бүртгэл, авто үйлчилгээний мэдээллийн нэгдсэн сан байгуулах, ашиглах, мэдээлэл солилцох журам боловсруулан хэрэгжүүлэх	-	ЗТЯ	ГЕГ ТЕГ АТҮТ	2016 он
1.4.	Зохих хугацаанд улсын бүртгэлд бүртгүүлээгүй, бүртгэлээс хасуулаагүй, техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх хяналт, хариуцлагын тогтолцоог шинэчлэх	10.0	ЗТЯ	АТҮТ	2015-2016 он
1.5.	Автотээврийн салбарын баталгаажуулалтын Зөвлөл байгуулах, шинжээчдийг бэлтгэх		ЗТЯ	СХЗГ	2015 он
1.6.	Техникийн хяналтын үзлэгийн төв, тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох болон тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээ хийх үйлчилгээний стандартыг тогтоон мөрдүүлэх	10.0	АТҮТ	ЗТЯ СХЗГ	2016 он
1.7.	Техникийн хяналтын үзлэгийн төв, авто үйлчилгээний байгууллагад ашиглагдаж байгаа техник тоног төхөөрөмжийг баталгаажуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх,	20.0	АТҮТ	ЗТЯ СХЗГ	2017 он
1.8.	Техникийн хяналтын үзлэгийн явуулын станцын стандарт боловсруулж мөрдүүлэх	10.0	АТҮТ	ЗТЯ СХЗГ	2017 он
1.9.	Авто үйлчилгээний байгууллагад ангилал тогтоох журмыг шинэчлэн боловсруулах	-	ЗТЯ	ТББ	2015 он

1.10	Ашиглалтаас хасагдсан тээврийн хэрэгслийг устгах, дахин боловсруулах эрх зүйн зохицуулалтыг бий болгох	40.0	ЗТЯ	АТҮТ	2016-2017 он
1.11.	Монгол Улсад үйлдвэрлэсэн, угсарсан тээврийн хэрэгсэлд үйлдвэрлэгчийн таних тэмдэг олгох, зохицуулалтыг бүрдүүлэх	10.0	ЗТЯ	АТҮТ	2015 он
1.12.	Тээврийн хэрэгслийн бүртгэлийн ажилтны эрх, үүргийг тодорхой болгон хуульчлах	20.0	ЗТЯ	АТҮТ	2015-2016 он
1.13.	Тээврийн хэрэгслийн бүртгэл хийх, бүртгэлийн дугаар олгох үйлчилгээг цахим хэлбэрээр хийх тогтолцоог бүрдүүлэх	100.0	ЗТЯ	АТҮТ	2017-2018 он
1.14.	Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний мэдээллийн цахим архив бүрдүүлэх зохицуулалтыг бий болгох	100.0	АТҮТ	ЗТЯ ТББ	2016-2017 он
Хоёр. Нийгмийн эрэлт хэрэгцээ, техник технологийн дэвшилд суурилсан үйлчилгээг өргөжүүлэн хөгжүүлнэ;					
2.1.	Тээврийн хэрэгслийн хийц, технологийн онцлогт тохируулан техникийн хяналтын үзлэг, засвар үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх	50.0	АТҮТ	ЗТЯ	2016-2017 он
2.2.	Техникийн хяналтын үзлэгийн дүгнэлтийг цахим хэлбэрээр хэрэглэгчдэд хүргэх үйлчилгээг нэвтрүүлэх	150.0	АТҮТ	ЗТЯ	2015 он
2.3.	Техникийн хяналтын үзлэгийн технологийн картыг шинэчлэн боловсруулах	-	АТҮТ	ЗТЯ	2016-2017 он
2.4.	“Сонгино хайрхан” техникийн хяналтын төвийг түшиглэн сургалт, дадлагын төв байгуулах	1.000.0	АТҮТ		2017-2018 он
2.5.	Техникийн хяналтын үзлэгийн дүгнэлтэд үндэслэн хөдөлгөөний аюулгүй байдлын болон техникийн аюулгүй байдлыг хангах талаар хэрэглэгчдэд зөвлөмж өгөх “зөвлөн туслах” үйлчилгээг хөгжүүлэх;	10.0	АТҮТ	ЗТЯ НТГ	2016-2017 он
2.6.	Тээврийн хэрэгслийн бүртгэл хөтлөх, дугаар олгох үйлчилгээнд цахим үйлчилгээний системийг нэвтрүүлэх;	200.0	АТҮТ	ЗТЯ	2018-2020 он
2.7.	Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний цахим архив бий болгох.	100.0	ЗТЯ	АТҮТ НТГ МАИХ	2016-2019 он
2.8.	Техник, тоног төхөөрөмж, үйлчилгээний хүрээнээс хамааран авто үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагаанд зэрэглэл тогтоох;	-	ЗТЯ	АТҮТ НТГ	2016-2019 он
2.9.	Техникийн сорилт, туршилт, баталгаажуулалтын нэгдсэн лаборатори байгуулах	300.0	ЗТЯ	АТҮТ СХЗГ	2018-2020 он
2.10.	Техник, тоног төхөөрөмжийн хүчин чадал, инженер, техникийн ажилтнуудын мэргэжлийн ур чадварыг харгалзан техникийн хяналтын үзлэгийн төвүүдийн үйл ажиллагаанд зэрэглэл тогтоох;	-	ЗТЯ	МХЕГ	2016-2017 он

авто үйлчилгээний лтыг хөгжүүлэх замаар лэх;	-	ЗТЯ	АТҮТ НТГ МХЕГ	2016-2017 он
алаар үйл ажиллагаа йн бус байгууллагатай ан ажиллах	100.0	АТҮТ, Нийслэлийн тээврийн газар	ЗТЯ	2015-2020 он
н бүртгэлийн хүрээнд камтран “татварын улнэ	50.0	АТҮТ	ЗТЯ	2016-2017 он
эдээлэлд тулгуурлан лүүлэх, зам тээврийн нд үзүүлж буй сөрөг судалгаа, шинжилгээ всруулан холбогдох	30.0	АТҮТ	ЗТЯ, НАЧА, ЦЕГ, ШУТИС-ийн МИС, БОНХЯ	2014-2020 он
төв болон, засвар Чанарын удирдлагын улэх	5.0	АТҮТ	СХЗГ	2016-2018 он
с шууд нийлүүлж буй дэмжих бодлого	-	ЗТЯ	АТҮТ	2016-2020 он
чадамжид суурилсан тогтолцоо”-г бүрдүүлэх;				
эргэжлийн стандартыг журам боловсруулан	20.0	ЗТЯ АТҮТ	СХЗГ Мэргэжлийн холбоод	2016-2017 он
тгэлийн чиглэлээр берийг боловсруулан	50.0	ЗТЯ	Мэргэжлийн холбоод	2016 он
бусад оронд сургах, солилцох зэргээр р, техникийн ажилтан	150.0	ЗТЯ АТҮТ	ШУТИС-МИС Мэргэжлийн холбоод	2015-2019 он
жиллах нөхцөл, эрүүл асан орчин нөхцөлийг	50.0	ЗТЯ	АТҮТ НТГ	2017-2019 он
тасралтгүй суралцах, улэх журам, сургалтын лэх	5.0	ЗТЯ	НАРТАМ, АТҮТ, НТГ,	2017 он
үүлэх	80.0	АТҮТ		2014 он
то үйлчилгээ, бүртгэлийн үйл ажиллагааны техник, тоног төхөөрөмж, програм				